



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 68

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Сайнцагаан сумын Гуравдугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 5,248,727 /таван сая хоёр зуун дөчин найман мянга долоон зуун хорин долоо/ төгрөгийн балансын үнэтэй, 372,298 /гурван зуун далан хоёр мянга хоёр зуун ерэн найм/ төгрөгийн элэгдэл бүхий цэвэр бохир усны шугамыг хавсралтын дагуу аймгийн “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Сайнцагаан сумын Гуравдугаар цэцэрлэгийн эрхлэгч Г.Мөнхтуяа, “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 09-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.С. С.СҮХБААТАР



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын
08-дрийн 08 тогтоолын нэгдүгээр хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Цэвэр усны шугам	2019/01/01	диаметр	32.45	41,379.20	1,342,755.04	111,895.39	1,230,859.65
2	Бохир усны шугам	2019/01/01	диаметр	120.70	32,361.00	3,905,972.70	260,403.01	3,645,569.39
3	НИЙТ ДҮН					5,248,727.74 /таван сая хоёр зуун дөчин найман мянга долоон зуун хорин долоон төгрөг/	372,298.40 /гурван зуун далан хоёр мянга хоёр зуун ерэн найман төгрөг/	4,876,429.34 /дөрвөн сая найман зуун далан зургаан мянга дөрвөн зуун хорин есөн төгрөг/